



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/54/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: О.Алтансүх Утас: 99077045 Цахим хаяг: Altansukho52@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын сүүрх сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Л.АЮУРЗАНА ТАНАА Г

2020.02.27 № 1/172

танай _____ -ны № _____ -г

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005070120


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрхлэгч Л.Аюурзана танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.21-наас 2020.02.23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор О.Алтансүх хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.23-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүүхэд эерэг зан чанар, зөв хандлагыг төлөвшүүлэн, бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн чадамжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн ACOLOUS болон цалингийн Payroll программ” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн

үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 34 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 28 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд,” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 632415,5 мянган төгрөгөөс тооцон 12648,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14828,9 мянган төгрөгөөр буюу 1,2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	9,694,5	2,302,8	-7,391,6
Бараа материал	83,393,9	89,021,1	5,627,1
Үндсэн хөрөнгө	1,394,966,2	1,409,769,8	14,803,5
	-69703,4	-97571,4	-27868,0
Хуримтлагдсан элэгдэл	-69703,3	-27,867,9	-41835,4
Нийт хөрөнгө	<u>1,418,351,4</u>	<u>1,403,522,4</u>	-14,828,9
Өр төлбөр	<u>22,4</u>	<u>22,4</u>	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,418,328,9	1,403,499,9	-14,828,9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>1,418,351,4</u>	<u>1,403,522,4</u>	-14,828,9

Бараа материалын дансны үлдэгдэл 5627,1 мянган төгрөгөөр өссөн нь хүнсний болон бусад барилгын засварын материал, бусад хангамжийн бараа материал худалдан авч зарцуулаагүйгээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл тайлант онд 14803,5 мянган төгрөгөөр өссөн нь 7842,3 мянган төгрөгийн тавилга эд хогшил хандиваар ирсэн, 6961,2 мянган төгрөгөөр машин тоног төхөөрөмж, номын фонд, тавилга эд хогшилын тус тус хөрөнгө худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 27867,9 мянган төгрөгөөр тайлант оны элэгдлийн зардлаар нэмэгдэж 97571,4 мянган төгрөг болсон байна.

Биет бус хөрөнгө нь санхүүгийн программ 1312,0 мянган төгрөг, газар 141475,0 мянган төгрөгийн өртөгтэй дансанд бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1403499,9 мянган төгрөг болж өмнөх оноос 14828,9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байхгүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 70101 хөтөлбөрт зориулан 609744,2 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 488337,6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 121406,6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 608368,1 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь улсын төсвөөс 488337,6 мянга, орон нутгийн төсвөөс 121406,6 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд зарцуулж 1376,0 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв:

Тус байгууллагын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаарх авлага 9543,4 мянган төгрөгийг Аймгийн ЗДТГ-ын Төрийн сангаар дамжуулан нэмэлт дансандаа авч тавилга эд хогшил худалдан авахад 9190,0 мянган төгрөгийг зарцуулж 353,4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 34 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 28 эрсдэл тодорхойлж нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 13025,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 9543,4 мянган төгрөгийн алдааг залруулж, 1 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгч 1 алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Аудитаар дараах 3481,6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1851,6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүллээ. Үүнд

Илрүүлэлт:

1. 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд авлагаар тусгасан 9543.4 мянган төгрөгийг барагдуулан нэмэлт санхүүжилтийн дансаар буцаан авч мөнгөн гүйлгээний тайланд дансны бичилт буруу хийж орлого авч нэмэлт санхүүжилтийн дансаар орсон орлогыг үндсэн дансны хуулгаар боловсруулалт хийсэн байна. Иймд 2019 оны санхүүгийн тайланд Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалын хавсралт-1 дагаж мөрдөж ажиллах гэсэн заалтын дагуу нэмэлт санхүүжилтийн орлогын 131105 дансанд орлогыг бүртгэж тайланд залруулга хийлгэлээ.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулав

2. Тайланд оны эцэст 2851,6 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй бөгөөд үлдэгдлийг түүвэрлэж тулгахад мах, сүү, зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг төсөвтэй харьцуулахад их хэмжээгээр авч хүнсний нөөцийг бэлдсэн байгаа нь хадгалалтын хугацаа алдагдах, чанар байдал өөрчлөлт орох хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал хангахгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 45 дугаар зүйлийн “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 4-т “Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 151 мэдээллээс хугацаанд нь 134 мэдээллийг , 17 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Тайлбар
1	Бүтэн жил	11	11	10	1		
2	Хагас жил	4	4	4			
3	Улирал бүр	1	4	4			
4	Сар бүр	3	36	36			
5	Тухай бүр	8	96	80	16		
	Нийт	27	151	134	17		

2019 оны тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээний 10 сарын мэдээ, бүтэн жилээр тавих худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний

тендерийн ерөнхий мэдээллийн 1-9 –р саруудын мэдээ, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэг хаяг мэдээний 3-р сарын мэдээ, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр мэдээний 2, 5, 8, 9, 12-р сарын мэдээг тус тус хугацаа хоцроосон байна.

Хугацаа хоцроосон тайлбарыг нягтлан бодогчоос авахад алдаатай буруу оруулсан мэдээллийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс шалгаж мэдээллийг засуулж оруулснаас хугацаа хоцроосноор бүртгэгдсэн байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Байхгүй

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор 1 дүгээр цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

2008 онд Ординат ХХК-с авсан 630,0 мянган төгрөгийн үнэтэй санхүүгийн VINNICA программыг НББ-ийн үйл ажиллагаанд ашиглагдахгүй, байгууллагын хөрөнгөөс хасаагүй байв.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд хөрөнгө буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1-т “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэсэн заалтыг дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>93,088,505.14</u>	<u>91,323,981.95</u>
33	АВЛАГА	9,694,567.35	2,302,872.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	151,167.35	66,125.00
335	Бусад авлага	9,543,400.00	2,236,747.00
3351	Байгууллагаас авах авлага	9,543,400.00	2,236,747.00
35	БАРАА МАТЕРИАЛ	83,393,937.79	89,021,109.95
351	Түүхий эд материал	259,839.12	431,539.12
35130	Эм боох материал	259,839.12	431,539.12
354	Хангамжийн материал	83,134,098.67	88,589,570.83
35410	Бичиг хэргийн материал	1,782,090.00	1,877,490.00
35420	Аж ахуйн материал	20,890,857.80	21,674,782.80
35440	Түлш, шатах тослох материал	3,026,333.40	240.56
35450	Барилгын засварын материал	1,102,570.00	1,412,000.00
35460	Хүнсний материал	2,834,830.07	2,851,640.07
35470	Бусад хангамжийн материал	53,497,417.40	60,773,417.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,325,262,916.33</u>	<u>1,312,198,447.63</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,325,262,916.33	1,312,198,447.63
392	Биет хөрөнгө	1,183,787,916.33	1,170,723,447.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,158,242,125.71	1,158,242,125.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	-25,645,234.40	-44,879,160.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,792,178.00	51,942,178.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-29,378,567.11	-34,034,689.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,937,912.34	49,560,227.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,165,299.40	-17,131,201.15
39209	Зам, гүүрийн байгууламж	57,500.00	57,500.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-57,500.00	-57,500.00
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	1,052,720.00	1,052,720.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	-144,782.31	-156,816.63
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,681,863.50	2,681,863.50
39217	Ном	3,415,000.00	3,446,200.00
393	Биет бус хөрөнгө	141,475,000.00	141,475,000.00
39301	Програм хангамж	1,312,000.00	1,312,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,312,000.00	-1,312,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	141,475,000.00	141,475,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,418,351,421.47</u>	<u>1,403,522,429.58</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>22,499.92</u>	<u>22,499.92</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,499.92	22,499.92
413	Өглөг	22,499.92	22,499.92
41361	Байгууллагад төлөх өглөг	22,499.92	22,499.92
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,418,328,921.55</u>	<u>1,403,499,929.66</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,418,328,921.55	1,403,499,929.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	248,814,143.50	248,814,143.50
51101	Өмч: - төрийн	248,814,143.50	248,814,143.50
512	Хуримтлагдсан үр дүн	1,003,368,664.62	988,539,672.73
51210	Өмнөх үеийн үр дүн	1,003,368,664.62	1,003,368,664.62
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-14,828,991.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	166,146,113.43	166,146,113.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,418,351,421.47</u>	<u>1,403,522,429.58</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	556,142,512.00	617,586,515.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,633,300.00	7,842,315.52
120	Нийтлэг татварын бус орлого	14,633,300.00	7,842,315.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,633,300.00	7,842,315.52
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,633,300.00	7,842,315.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	37,874,712.00	121,406,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	503,634,500.00	488,337,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	121,406,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	121,406,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	549,510,804.69	632,415,507.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	549,510,804.69	632,415,507.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	523,820,103.98	629,786,040.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,205,422.00	335,362,890.00
210101	Үндсэн цалин	235,205,422.00	335,362,890.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,671,700.11	44,604,952.35
210201	Тэтгэврийн даатгал	28,671,700.11	44,604,952.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,266,509.00	116,906,600.00
210301	Гэрэл, цахилгаан	6,990,660.00	14,181,864.00
210302	Түлш, халаалт	36,749,477.00	37,672,144.00
210303	Цэвэр, бохир ус	18,526,372.00	20,052,592.00
210304	Байрны түрээс	45,000,000.00	45,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,661,968.01	6,923,429.34
210401	Бичиг хэрэг	1,513,540.00	1,545,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,195,275.18	2,651,092.84
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	822,542.83	928,861.50
210404	Ном, хэвлэл	135,000.00	90,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	280,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	995,610.00	1,428,275.00
2105	Нормативт зардал	78,305,688.19	90,787,565.00
210502	Хоол, хүнс	77,605,040.00	90,787,565.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	777,080.00	3,672,220.00
210604	Урсгал засвар	777,080.00	3,672,220.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	763,000.00	1,060,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	763,000.00	810,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,027,736.67	30,467,884.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	135,000.00	2,599,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,380,286.67	27,867,984.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,690,700.71	2,629,466.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,445,282.00	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	424,400.00	900,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	482,250.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	482,250.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,247,216.50

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,247,216.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,631,707.31	-14,828,991.89
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-81,271,108.49	-14,828,991.89

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	541,509,212.00	619,287,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	541,509,212.00	619,287,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	503,634,500.00	488,337,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,757,230.00	9,543,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	9,543,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	121,406,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	121,406,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	541,509,212.00	619,287,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	541,509,212.00	619,287,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	515,818,511.29	616,656,133.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,742,589.46	339,928,247.00
210101	Үндсэн цалин	208,009,107.00	283,586,238.00
210102	Нэмэгдэл	13,825,400.00	30,056,553.00
210104	Урамшуулал	14,908,082.46	26,285,456.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,285,700.00	42,183,300.00
210201	Тэтгэврийн даатгал	20,570,187.00	29,061,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,244,900.00	3,280,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,821,100.00	2,624,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	455,300.00	656,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,194,213.00	6,560,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	110,066,509.00	114,106,600.00
210301	Гэрэл, цахилгаан	6,990,660.00	14,181,864.00
210302	Түлш, халаалт	39,549,477.00	34,872,144.00
210303	Цэвэр, бохир ус	18,526,372.00	20,052,592.00
210304	Байрны түрээс	45,000,000.00	45,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,394,852.83	8,042,461.50
210401	Бичиг хэрэг	852,500.00	762,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,239,700.00	2,425,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	822,542.83	928,861.50
210404	Ном, хэвлэл	135,000.00	166,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,345,110.00	3,579,800.00
2105	Нормативт зардал	91,546,130.00	91,906,475.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	104,700.00	51,700.00
210502	Хоол, хүнс	75,060,430.00	90,804,375.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,381,000.00	1,050,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,174,100.00	7,171,150.00
210604	Урсгал засвар	1,174,100.00	7,171,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	758,600.00	9,918,000.00

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	758,600.00	9,718,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,709,030.00	3,399,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	3,399,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,690,700.71	2,631,466.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,445,282.00	902,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	424,400.00	902,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	482,250.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	482,250.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,247,216.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,247,216.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөг/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	107,339,143.50	165,234,686.00	-53,523,126.95	219,050,702.55
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-25,030,525.83	-25,030,525.83
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	248,814,143.50	166,146,113.43	1,003,368,664.62	1,418,328,921.55
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	248,814,143.50	166,146,113.43	1,003,368,664.62	1,418,328,921.55
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	248,814,143.50	166,146,113.43	1,003,368,664.62	1,418,328,921.55
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-14,828,991.89	-14,828,991.89
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	248,814,143.50	166,146,113.43	988,539,672.73	1,403,499,929.66

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	609,744,200.00	608,368,133.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	609,744,200.00	608,368,133.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	608,630,200.00	607,466,133.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	339,928,800.00	339,928,247.00
210101	Үндсэн цалин	281,952,300.00	283,586,238.00

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210102	Нэмэгдэл	32,293,300.00	30,056,553.00
210104	Урамшуулал	25,683,200.00	26,285,456.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,183,300.00	42,183,300.00
210201	Тэтгэврийн даатгал	29,061,800.00	29,061,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,280,300.00	3,280,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,624,400.00	2,624,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	656,100.00	656,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,560,700.00	6,560,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,106,600.00	114,106,600.00
210301	Гэрэл, цахилгаан	11,517,600.00	14,181,864.00
210302	Түлш, халаалт	37,327,000.00	34,872,144.00
210303	Цэвэр, бохир ус	20,262,000.00	20,052,592.00
210304	Байрны түрээс	45,000,000.00	45,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,079,700.00	8,042,461.50
210401	Бичиг хэрэг	230,400.00	762,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,340,000.00	2,425,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,494,500.00	928,861.50
210404	Ном, хэвлэл	128,000.00	166,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,706,800.00	3,579,800.00
2105	Нормативт зардал	92,071,700.00	91,906,475.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	119,500.00	51,700.00
210502	Хоол, хүнс	90,804,400.00	90,804,375.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,147,800.00	1,050,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,692,600.00	7,171,150.00
210604	Урсгал засвар	7,692,600.00	7,171,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	780,300.00	728,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	580,300.00	528,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3548200.00	3399900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,548,200.00	3,399,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1114000.00	902000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,114,000.00	902,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,114,000.00	902,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	609,744,200.00	608,368,133.50
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	488,337,600.00	487,090,383.50
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	488,337,600.00	487,090,383.50
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	121,406,600.00	121,277,750.00
132001	Орон нутгийн төсвөөс	121,406,600.00	121,277,750.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38.00	38.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	340.00	378.00

631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	340.00	378.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	340.00	378.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38.00	38.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	22.00	22.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16.00	16.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт:

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,190,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,190,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,190,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,190,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,190,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9190000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,190,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,190,000.00

Аудитын тайланг

Хясан:

Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат 2018.02.12

Аудитын менежер А.Цээням 2018.02.12

Бэлтгэсэн:

Аудитор О.Алтансүх 2018.02.12

